



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас 70-59-24-39 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.08.18 № 09/55

ЭРДЭНЭДАЛАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.МӨНХБААТАР ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аudit хийх явцад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 30,000,000.00 /Гучин сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй “Инженерийн хийцтэй худаг” гаргах ажлын худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах/ТБОНӨХБАУХА/ тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.-д/Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно/ 8.1.2-т /Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/, 33 дугаар зүйлийн 33.1 –д /Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ/, хавсралтын 2-т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 10.0 сая/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн A/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа,


13010600712

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Засаг дарга С.Мөнхбаатар, засаг даргын орлогч Г.Батжаргал, санхүү албаны дарга Г.Энхтайван нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.